



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны  
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/46/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дархан-Уул аймаг 2025 он	Газрын дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас:70373089, 99023682 Цахим хаяг:munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас:99023682 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас:99377479 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Пийк ОМ Аудит ХХК Захирал: Б.Жаргалсайхан Утас:99862066 Цахим хаяг:peakomauditllc@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	3
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд...	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	13
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.2 Материаллаг байдал.....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	14

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН  
АЛБАНЫ ДАРГА Л.ДАГИЙСҮРЭН ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоосноор цалингийн зардал өнгөрсөн оны гүйцэтгэлээс 86.8 хувиар өссөн байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн хяналт дотоод аудитын алба нь байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 19 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 97.3 хувиар тайлагнасан байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР

## **2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

---

### **2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>9,860,819.00</b>	<b>19,413,780.00</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	9,860,819.00	19,413,780.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	9,860,819.00	19,413,780.00
35410	Бичиг хэргийн материал	1,481,670.00	1,426,020.00
35420	Аж ахуйн материал	1,309,290.00	8,946,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,321,100.00	2,250,000.00
35470	Бусад хангамжийн материал	5,748,759.00	6,791,760.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>26,306,503.52</b>	<b>36,578,140.24</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	26,306,503.52	36,578,140.24
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	25,123,920.07	34,841,795.08
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	42,777,400.00	45,071,600.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(21,898,729.93)	(16,113,375.75)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,855,000.00	13,635,500.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(6,609,750.00)	(7,751,929.17)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	1,182,583.45	1,736,345.16
39301	Програм хангамж	1,924,300.00	1,124,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,924,300.00)	(18,738.33)
39303	Бусад биет бус хөрөнгө	2,759,000.00	2,759,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(1,576,416.55)	(2,128,216.51)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>36,167,322.52</b>	<b>55,991,920.24</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>36,167,322.52</b>	<b>55,991,920.24</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	36,167,322.52	55,991,920.24
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	36,167,322.52	55,991,920.24
51210	Өмнөх үеийн үр дүн	32,272,491.77	36,167,322.52
51220	Тайлант үеийн үр дүн	3,894,830.75	19,824,597.72
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>36,167,322.52</b>	<b>55,991,920.24</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>304,787,100.00</b>	<b>559,823,700.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>0.00</b>	<b>8,779,200.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	0.00	8,779,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	8,779,200.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	8,779,200.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>304,787,100.00</b>	<b>551,044,500.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>0.00</b>	<b>2,000,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	2,000,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>304,787,100.00</b>	<b>549,044,500.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	304,787,100.00	549,044,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>300,892,269.25</b>	<b>539,999,102.28</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>300,892,269.25</b>	<b>539,999,102.28</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>292,599,509.67</b>	<b>298,534.55</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>212,734,280.54</b>	<b>397,403,381.87</b>
210101	Үндсэн цалин	105,553,341.40	181,344,421.54
210102	Нэмэгдэл	76,876,069.34	169,423,660.33
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,320,000.00	21,720,000.00
210104	Урамшуулал	22,984,869.80	24,915,300.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>27,563,757.08</b>	<b>44,704,600.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	18,951,323.37	29,292,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,231,508.60	3,622,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,706,006.93	1,964,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	426,501.74	1,964,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,248,416.44	7,859,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>9,081,788.80</b>	<b>13,561,800.40</b>
210401	Бичиг хэрэг	3,090,746.00	6,265,850.00
210402	Тээвэр, шатахуун	2,891,080.00	4,351,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,314,422.80	2,152,450.40
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,785,540.00	792,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>15,280,900.00</b>	<b>13,982,700.00</b>
210702	Дотоод албан томилолт	15,280,900.00	13,982,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,027,000.00</b>	<b>1,300,000.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	530,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	527,000.00	770,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>26,911,783.25</b>	<b>31,346,052.28</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,757,420.00	18,908,889.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,416,700.00	1,200,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,737,663.25	11,237,163.28
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>8,292,759.58</b>	<b>37,700,567.73</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,750,000.00</b>	<b>37,699,309.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	34,724,309.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,750,000.00	2,975,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>5,542,759.58</b>	<b>1,258.73</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,542,759.58	1,258.73
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>3,894,830.75</b>	<b>19,824,597.72</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>3,894,830.75</b>	<b>19,824,597.72</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>304,787,100.00</b>	<b>551,044,500.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>304,787,100.00</b>	<b>551,044,500.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0.00	2,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	2,000,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>304,787,100.00</b>	<b>549,044,500.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	304,787,100.00	549,044,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>293,177,700.00</b>	<b>538,314,900.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>293,177,700.00</b>	<b>538,314,900.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>284,884,940.42</b>	<b>500,614,332.27</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>212,734,280.54</b>	<b>397,403,381.87</b>
210101	Үндсэн цалин	105,553,341.40	181,344,421.54
210102	Нэмэгдэл	76,876,069.34	169,423,660.33
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,320,000.00	21,720,000.00
210104	Урамшуулал	22,984,869.80	24,915,300.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>27,563,757.08</b>	<b>44,704,600.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	18,951,323.37	29,292,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,231,508.60	3,622,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,706,006.93	1,964,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	426,501.74	1,964,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,248,416.44	7,859,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>9,234,202.80</b>	<b>13,728,250.40</b>
210401	Бичиг хэрэг	3,000,000.00	5,071,400.00
210402	Тээвэр, шатахуун	3,974,100.00	5,280,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,317,502.80	2,152,450.40
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	942,600.00	1,224,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,120,000.00</b>	<b>8,810,400.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,120,000.00	310,400.00
210604	Урсгал засвар	0.00	8,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>15,280,900.00</b>	<b>13,982,700.00</b>
210702	Дотоод албан томилолт	15,280,900.00	13,982,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,027,000.00</b>	<b>1,300,000.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	530,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	527,000.00	770,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>15,924,800.00</b>	<b>20,685,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,508,100.00	17,685,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,416,700.00	3,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>8,292,759.58</b>	<b>37,700,567.73</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,750,000.00</b>	<b>37,699,309.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	34,724,309.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,750,000.00	2,975,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>5,542,759.58</b>	<b>1,258.73</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,542,759.58	1,258.73
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>11,609,400.00</b>	<b>12,729,600.00</b>

	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>11,609,400.00</b>	<b>12,729,600.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>11,609,400.00</b>	<b>12,729,600.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>11,609,400.00</b>	<b>12,729,600.00</b>
223001	Бусад хөрөнгө	11,609,400.00	12,729,600.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(11,609,400.00)</b>	<b>(12,729,600.00)</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	0.00	0.00	32,272,491.77	0.00	32,272,491.77
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>32,272,491.77</b>	<b>0.00</b>	<b>232,272,491.77</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					
C07	Тайлант үеийн үр дүн			3,894,830.75		3,894,830.75
C08	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>36,167,322.52</b>	<b>0.00</b>	<b>36,167,322.52</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>36,167,322.52</b>	<b>0.00</b>	<b>36,167,322.52</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					
D08	Тайлант үеийн үр дүн			19,824,597.72		19,824,597.72
D09	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>55,991,920.24</b>	<b>0.00</b>	<b>55,991,920.24</b>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>594,587,500.00</b>	<b>549,043,241.27</b>	<b>45,544,258.73</b>	<b>92.3</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>594,587,500.00</b>	<b>549,043,241.27</b>	<b>45,544,258.73</b>	<b>92.3</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>511,399,100.00</b>	<b>511,343,932.27</b>	<b>55,167.73</b>	<b>100.0</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>392,987,400.00</b>	<b>392,984,581.87</b>	<b>2,818.13</b>	<b>100.0</b>
210101	Үндсэн цалин	181,347,100.00	181,344,421.54	2,678.46	100.0
210102	Нэмэгдэл	178,799,800.00	165,004,860.33	13,794,939.67	92.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,398,000.00	21,720,000.00	(8,322,000.00)	162.1
210104	Урамшуулал	19,442,500.00	24,915,300.00	(5,472,800.00)	128.1
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>49,123,400.00</b>	<b>49,123,400.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210201	Тэтгэврийн даатгал	33,403,900.00	33,403,900.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	3,929,900.00	3,929,900.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,964,900.00	1,964,900.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,964,900.00	1,964,900.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	7,859,800.00	7,859,800.00	-	100.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>13,728,300.00</b>	<b>13,728,250.40</b>	<b>49.60</b>	<b>100.0</b>
210401	Бичиг хэрэг	5,281,200.00	5,071,400.00	209,800.00	96.0
210402	Тээвэр, шатахуун	5,282,600.00	5,280,000.00	2,600.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,977,700.00	2,152,450.40	(174,750.40)	108.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,186,800.00	1,224,400.00	(37,600.00)	103.2
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>21,035,000.00</b>	<b>21,000,000.00</b>	<b>35,000.00</b>	<b>99.8</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,500,000.00	12,500,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	8,535,000.00	8,500,000.00	35,000.00	99.6
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>14,000,000.00</b>	<b>13,982,700.00</b>	<b>17,300.00</b>	<b>99.9</b>
210702	Дотоод албан томилолт	14,000,000.00	13,982,700.00	17,300.00	99.9
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,300,000.00</b>	<b>1,300,000.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	530,000.00	530,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	770,000.00	770,000.00	-	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>19,225,000.00</b>	<b>19,225,000.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,625,000.00	15,625,000.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,600,000.00	3,600,000.00	-	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>83,188,400.00</b>	<b>37,699,309.00</b>	<b>45,489,091.00</b>	<b>45.3</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>83,188,400.00</b>	<b>37,699,309.00</b>	<b>45,489,091.00</b>	<b>45.3</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,674,400.00	0.00	38,674,400.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	41,514,000.00	34,724,309.00	6,789,691.00	83.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	2,975,000.00	25,000.00	99.2

III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>594,587,500.00</b>	<b>549,043,241.27</b>	<b>45,544,258.73</b>	<b>92.3</b>
32	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>594,587,500.00</b>	<b>549,043,241.27</b>	<b>45,544,258.73</b>	<b>92.3</b>
320001	Орон нутгийн төсвөөс	594,587,500.00	549,043,241.27	45,544,258.73	92.3
6	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>21</b>	<b>21</b>	<b>-</b>	<b>100.0</b>
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>100.0</b>
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>10</b>	<b>10</b>	<b>-</b>	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9	-	100.0
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>10</b>	<b>10</b>	<b>-</b>	<b>100.0</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	9	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1	1	-	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>0</b>	<b>2,000,000.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>0</b>	<b>2,000,000.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>0</b>	<b>2,000,000.00</b>
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>0</b>	<b>0</b>
210401	Бичиг хэрэг	0	0
210402	Тээвэр, шатахуун	0	0
210406	Хог хаягдал, хортон шавьж	0	0
2105	<b>Нормативт зардал</b>	<b>0</b>	<b>0</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0	0
210502	Хоол, хүнс	0	0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0	0
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>0</b>	<b>0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	0	0
210602	Тавилга	0	0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0	0
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>0</b>	<b>2,000,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0	2,000,000.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>0</b>	<b>0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	0
2133	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>0</b>	<b>0</b>
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	0	0
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>0</b>	<b>2,000,000.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>0</b>	<b>2,000,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	2,000,000.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>0</b>	<b>0</b>
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0</b>	<b>0</b>
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0</b>	<b>0</b>

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт дотоод аудит хийх, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангаж тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх гэж зорилгоо тодорхойлон үйл ажиллагаа явуулж байна.

Тус байгууллага нь төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, Засгийн газрын тусгай сан, төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, тусламж, эргэн төлөгдөх нөхцөлөөр ашиглуулж байгаа хөрөнгө, олон улсын байгууллага, гадаад орны Засгийн газар, байгууллага, иргэдээс олгосон зээл, өгсөн хандив, тусламж тэдгээртэй адилтгах хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийх чиг үүргийг хэрэгжүүлдэг.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 03-ны өдрийн “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2024 оны 04 сарын 01-ний өдрийн “Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай” А52 дугаар тушаал;
- Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 238 дугаар тогтоол;

Монгол Улсын үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байгаа тул хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг улсын секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад нийцүүлэн, нягтлан бодох бүртгэлийн аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Албаны даргын 2020 оны 12-р сарын 17-ны өдрийн А/32 дугаар тушаалаар байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж эхэлсэн ба 2023 оны 01-р сарын 07-ны өдрийн

A/01 тушаалаар тус баримт бичигт шинээр гарсан хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу холбогдох хууль тогтоомж, стандартад нийцүүлэн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан баяжуулалтыг хийж дагаж мөрдөж ажиллаж байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 19,824.6 мянган төгрөгөөр буюу 54.8 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	9,860.8	19,413.8	9,553.0
Үндсэн хөрөнгө	26,306.5	36,578.1	10,271.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>36,167.3</b>	<b>55,991.9</b>	<b>19,824.6</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	36,167.3	55,991.9	19,824.6
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>36,167.3</b>	<b>55,991.9</b>	<b>19,824.6</b>

Тайлант онд бараа материалын дансны үлдэгдэл 19,413.8 мянган төгрөг болж 9,553.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр бичиг хэргийн материал 11,438.4 мянга, аж ахуйн материал 10,158.9 мянга, түлш шатах тослох материал 5,280.0 мянга, бусад хангамжийн материал 1,183.4 мянган төгрөгөөр худалдан авч, 18,829.2 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулснаар бараа материалын үлдэгдэл оны эцэст өссөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 36,578.1 мянган төгрөг болж өссөн нь цаашид ашиглах боломжтой, элэгдлээрээ өртгөө нөхсөн 13 нэр төрлийн хөрөнгүүдийг эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлж 8,779.2 мянган төгрөгөөр дахин үнэлсэн дүн болон төсвийн хөрөнгөөр олж бэлтгэсэн нийт 12,729.6 мянган төгрөгийн хөрөнгүүдийг бүртгэсэнтэй холбоотой. Тайлант онд 800.0 мянган төгрөгийн программ хангамжийг данснаас хасч, 11,237.6 мянган төгрөгийн элэгдэл тооцож, зардлаар хүлээн зөвшөөрсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 55,991.9 мянган төгрөг болж 19,824.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт болох Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 536,321.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 34,912.2 мянган төгрөг нэмэгдүүлж 571,233.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд орон нутгийн төсвийг 23,354.2 мянган төгрөг болгон нэмэгдүүлж тодотгол хийсэн байна

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны зардлыг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 594,587.5 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 549,044.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагаандаа 549,043.2 мянган төгрөгийг зарцуулан, 1.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	511,399.1	511,343.9	(55.2)	99.9
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал, дэмжлэг	83,188.4	37,699.3	(45,489.1)	45.3
	Дүн	594,587.5	549,043.2	(45,544.3)	92.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт санхүүжилтээр дээд шатны төсвийн захирагчаас 2,000.0 мянган төгрөг орж ирсэнээс хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардалд 2,000.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй болно.

#### Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл:

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2025 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн хооронд Пийк ОМ Аудит ХХК-ийн аудитор А.Батболд гүйцэтгэж, захирал Б.Жаргалсайхан хянан удирдаж, чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 24 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.



